



БНМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 01 сарын 06.

№ 03

Улаанбаатар
хот

Райодын биеийн тамир спортын
хорооны зохион байгуулалт, бүт-
цийн тухай

Монголын биеийн тамирын их хурлаас батлагдсан дүрмийг
үндэслэн Улаанбаатар хотын АХ-ын гүйцэтгэх захиргаанаас
ТОГТООХ нь:

1. Хоршоолол, Тээвэрчин, Барилгачин нийгэмлэгүүдийг татан
буулгаж Сүхбаатар, Октябрь, Найрамдалын райодын биеийн тамир
спортын хороод, хотын волейболын спортын клубийг одоо мөрдөж
байгаа цалингийн санд нь багтаан шинээр зохион байгуулж ажил-
луулахыг Хотын биеийн тамир спортын хороо, райодын АХ-ын гүй-
цэтгэх захиргаанд даалгасугай.

2. Шинээр байгуулагдаж байгаа биеийн тамир спортын хороодын
орон тоо зохион байгуулалтын бүтэц, цалингийн сан, төсвийг
баталж өгөхийг хотын санхүүгийн газар /н.Гонгор/-д даалгасугай.

3. Нийслэл хотын райодын хүн амын суурьшил байршилтын онц-
логийг харгалзан спортын сонгон суралцах дугуйлан, уралдаан
тэмцээнийг зохион байгуулах, нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтийг
хамарсан биеийн тамирын арга хэмжээ зохион явуулах бодлого,
төлөвлөлтийг боловсруулан хяналт тавих, материаллаг баазыг
бэхжүүлэх ажлыг анхан шатны хамтлаг, биеийн тамир спортын хороо
клубүүдэд түшиглэн тогтмол явуулж байхыг райодын АХ-ын гүйцэт-
гэх захиргаа, Хотын биеийн тамир спортын хороо /д.Содномзундуй/-д
даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын
АХ-ын гүйцэтгэх захиргааны 1990 оны 8-р сарын 02-ны өдрийн
175 дугаар тогтоолын 1,2,3,5 дугаар заалтуудыг хүчингүй бол-
сонд тооцсугай.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.ЭНЭБИШ
Ч.СУМААХҮҮ